



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
БАТ-ӨЛЗИЙ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 08 сарын 02 өдөр

Дугаар 1171

Бат-Өлзий сум

Хөрөнгө зарцуулах тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Засгийн газрын 2022 оны 02 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах тайлагнах журам”-ын 3.6.11, 3.6.16 дахь заалт, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын “2024 оны төсөвт батлах тухай” 2023 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн 18/03 дугаар тогтоолын 8 дугаар хавсралтын 2, 26 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Усны хамгаалалтын бүс тогтоох, тэмдэгжүүлэлт хийх зардалд 2,000,000 (хоёр сая) төгрөг, Байгаль хамгаалах аян зохион байгуулах зардалд 13,708,500 (арван гурван сая долоон зуун найман мянга таван зуу) төгрөг, нийт 15,708,500 (арван таван сая долоон зуун найман мянга таван зуу) төгрөгийг зарцуулсугай.

2. Зардлын тооцоог хавсралтаар баталсугай.

3. Зардалд шаардагдах 15,708,500 (арван таван сая долоон зуун найман мянга таван зуу) төгрөгийг Байгаль хамгаалах, нөхөн сэргээх зардлаас зарцуулахыг Засаг даргын Тамгын газрын нягтлан бодогч (Ч.Батдулам)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



С.АМГАЛАН

Сумын Засаг даргын 2024 оны
08... дугаар сарын 08...-ны өдрийн
дугаар захирамжийн нэгдүгээр хавсралт

БАЙГАЛЬ ХАМГААЛАХ АЯН ЗОХИОН БАЙГУУЛАХ ЗАРДЛЫН ТООЦОО

Д/д	Арга хэмжээний ажил, хэрэглэгдэх зүйлсийн нэр	Хэмжих нэгж тоо ширхэг	Нэгжийн үнэ	Нийт үнэ
	1	2	3	4
1	Байгаль хамгаалах мэдлэг, хандлагыг дээшлүүлэх чиглэлээр хүүхэд багачуудад сургалт зөвлөгөөнд хамруулах шатахууны зардалд	700	3700	2,590,000
2	Багуудад сургалт, сурталчилгаа хийх шатахууны зардалд	1050	3700	3,885,000
3	Байгаль хамгаалах аяны хүрээнд хяналт шалгалт зохион байгуулах шатахууны зардалд	875	3700	3,237,500
4	Мод бэлтгэлд хяналт тавих шатахууны зардалд	650	3700	2,405,000
5	Хортон устгалын ажилд хяналт тавих шатахууны зардалд	430	3700	1,591,000
Нийт дүн				13,708,500

УСНЫ ХАМГААЛАЛТЫН БҮС ТОГТООХ, ТЭМДЭГЖҮҮЛЭЛТ ХИЙХ ЗАРДЛЫН ТООЦОО

Д/д	Арга хэмжээний ажил, хэрэглэгдэх зүйлсийн нэр	Хэмжих нэгж тоо ширхэг	Нэгжийн үнэ	Нийт үнэ
1	2	3	4	5
1	Усны хамгаалалтын бүс тогтоож, тэмдэгжүүлэлтийн самбарын зардал	8	150 000	1 200 000
2	Усны хамгаалалтын бүс тогтоож, тэмдэгжүүлэлтийн самбар суурилуулах зардал	8	50 000	400 000
3	Ажлын дагалдах хэрэгсэл, шатахууны зардал	8	50 000	400 000
Нийт дүн				2 000 000